

**Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй
байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт**

2011,01,20

Булган

Аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Үр дүнгийн гэрээгээр 3 бүтээгдэхүүний 53, тусгай захиалгат 5, өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэхээр 3 зорилтын хүрээнд нийт 61 бүтээгдэхүүнийг нийлүүлж 90,8 хувьтай үнэллээ.

Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилийг тусгай удирдамж, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, явцыг удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөр, жилийн дүнг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлжээ.

Аймгийн хэмжээнд “Нийгмийн эрүүл мэндийн сумын тэргүүний салбар зөвлөл”-ийг шалгаруулах журмыг шинэчлэн боловсруулан сумдад хүргүүлэн ажиллаж, “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан үзүүлэх сургууль, нээлттэй өдөрлөгийг Орхон, Булган суманд зохион байгуулан, бүх сумдын удирдлагуудыг хамрууллаа.

Аймгийн Засаг даргаас Боловсрол, соёлын газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Боловсрол, соёлын газрын даргатай байгуулсан 2010 оны үр дүнгийн гэрээнд 4 бүтээгдэхүүний 32, тусгай захиалгат 4 бүтээгдэхүүний 12, өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх 1 бүтээгдэхүүний 13 арга хэмжээний биелэлтийг үнэлж дүгнэхэд 96.4 хувийн биелэлттэй дүгнэгдлээ.

Төрийн өмчийн 23 цэцэрлэг, байгууллагын 1 цэцэрлэгт 2294 хүүхэд хөгжиж цэцэрлэгийн хамран сургалт 54.5 хувьтай болж өмнөх оныхоос 4.4 хувиар өссөн байна. Зуны болон нүүдлийн цэцэрлэг, явуулын багшийн сургалтаар 1280 хүүхэд хамруулж 30.4 хувьтай, нийт Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 3574 хүүхэд буюу 85.5 хувьд хүрч өмнөх жилийнхээс 13.6 хувиар өссөн байна. 2010 онд хамран сургалтаараа **улсад тэргүүн байранд орлоо.**

Нийт сумдын соёлын төвийн 70.0 хувь нь үзэгчдийн сандлаар хангагдлаа.

Аймгийн Засаг даргаас Биеийн тамир спортын газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

2010 оны үр дүнгийн гэрээнд нийт 17 бүтээгдэхүүн, тусгай захиалгат бүтээгдэхүүн 4, өмчлөгчийн эрхийн 6 бүтээгдэхүүнийг нийлүүлэхээр гэрээ байгуулан биелэлтийг үнэлж дүгнэхэд 87,7 хувийн биелэлттэй дүгнэгдлээ.

Аймгийн Засаг даргын 2010 оны 375 дугаар захирамжийн дагуу Хүүхдийн спортын 4 дүгээр наадмыг аймагтаа хоёр үе шаттайгаар үндэсний спортын төрлүүдээр зохион байгуулж аймгийн шигшээ багийн тэмцээнд дахвардсан тоогоор 2467 хүн хамрагдлаа.

Үндэсний бөхийн сондгой сарын барилдааныг уламжлал болгон зохион байгуулж, эдгээр үйл ажиллагаагааг 60 гаруй албан байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран зохион байгууллаа. Монголын чөлөөт бөхийн холбооны санхүүжилтээр иж бүрэн дэвжээ, 10 ш хувцас, хэрэглэл, хүчний тоног төхөөрөмжөөр хангалаа.

Фургон машинтай болж, бүх ЕБС-иудын биеийн заалыг бөхийн дэвжээтэй болгоход 50,0 сая төгрөг зарцууллаа.

Аймгийн Засаг даргаас Хүүхдийн төлөө хэлтсийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

2010 оны үр дүнгийн гэрээнд 3 бүтээгдахүүний ангийн 12 нэр төрлийн, тусгай захиалгат 1 бүтээгдхүүний ангийн 4 нэр төрлийн, өмчлөгчийн 1 бүтээгдхүүний ангийн 3 нэрийн бүтээгдхүүн нийлүүлэхээр гэрээ байгуулан биелэлтийг үнэлж дүгнэхэд 99,6 хувийн биелэлттэй дүгнэгдлээ.

Хүүхдийн эрхийн асуудлаар эрх зүйн туслалцаа зөвлөгөө өгөх зорилгоор Хуульчдын зөвлөх баг ажиллууллаа.

ХТХ-ийн дэргэд ХБХ-ийг нөхөн сэргээх зорилгоор “Хамтдаа хөгжицгөөе” танхим гаргаж Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тэдний эцэг эхчүүдэд чиглэсэн сургалтуудыг зохион байгууллаа.

Монгол Улсад хүүхдийн байгууллага үүсч хөгжсөний 85 жилийн ойг тусгай төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу тэмдэглэх ажлыг зохион байгуулж Хүүхдийн парламент-2, Аймгийн засаг даргын ивээл дор зохион байгуулсан “**Булган хангайн хүүхдүүд**” урлагийн наадмыг зохион байгууллаа.

Үндэсний 4-р Жемборид хүүхдийн парламент скаутын төлөөлөл 10 хүүхэд 1 багш 1 салаа болон зохион байгуулагдан оролцож “**Шилдэг салаа**”-гаар шалгарлаа.

Аймгийн Засаг даргаас ХХААЖДҮ газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

ХХААЖДҮ газар гэрээгээр хүлээсэн үүргээ сайн биелүүлж 95,6 хувь буюу А үнэлгээтэй дүгнэгдсэн бөгөөд дараахи ажлуудыг сайн хийж гүйцэтгэсэн байна.

Аймгийн газар тариалангийн эргэлтийн талбайг 70580 га –д хүргэж, уринш бэлтгэлийг 100 хувь, техник шинчлэлийг 55 хувь, мал сүрэгт үзлэг ангилалтыг хугацаанд нь явуулж шаардлага хангаагүй малыг заазлаж, малыг зах зээлийн эргэлтэнд оруулсан.

Цөм сүрэг бүрдүүлэх арга хэмжээг оновчтой зохион байгуулж цөм сүргийн 5 аж ахуй байгуулсан.

Орон нутгийн нөөцөд түшиглэсэн үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэхэд зээл хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжихэд түлхүү анхаарч “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”-гийн үйл ажиллагааг сайн зохион байгуулж 4 томоохон үйлдвэр 10 гаруй жижиг, цех шинээр ашиглалтанд орлоо.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэлээр хангах зорилт дэвшүүлж төмсний хэрэглээг 100 хувь, гурилын хэрэгцээг 2 дахин их, хүнсний ногоо 65.0 хувь, махны хэрэгцээг 5 дахин их, сүүний хэрэгцээг 100.0 хувь дотоодын үйлдвэрлэлээр бэлтгэлээ.

Аймгийн Засаг даргаас Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Стандартчилал хэмжилзүйн хэлтэс нь гэрээгээр хүлээсэн үүргээ 95,8 хувьтай биелүүлж дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүллээ. Үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжиж нэн шаардлагатай 406 стандартаар хөнгөлттэй үнээр үйлчилж, аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа жин хэмжүүрийн 95 хувийг баталгаажуулалтанд хамруулж томоохон зах супермаркетуудад хяналтын жин ажиллуулж хэвшлээ.

Аймгийн Засаг даргаас Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга гэрээгээр хүлээсэн үүргээ сайн биелүүлж, тусгай захиалгат болон нийт 30 бүтээгдэхүүн, өмчлөгчийн эрхийг хангах 3 зорилтыг биелүүлж, 90,4 хувь буюу “А” үнэлгээтэй дүгнэгдсэн бөгөөд дараахь ажлуудад ахиц гаргасан байна. Ойн хортон устгалтын ажлыг 20500 га-д,

хортны тархалтын судалгааг 110,0 мянган га-д хийж, биелэлтийг 4 дахин давуулан биелүүлжээ.

Уул уурхайн нөхөн сэргээлтийн ажилд ахиц гарч, 144.9 га талбайд техникийн, 31,3 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг 80-аад хувийн амьдалттайгаар хийж гүйцэтгэжээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын батлагдсан төсвөөр 174350.1 мянган төгрөгийн санхүүжилт олгогдож, 161857,9 мянган төгрөг зарцуулж, 13455,0 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Аймгийн Засаг даргаас Газрын харилцаа, барилга хот байгуулалтын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Байгуулсан үр дүнгийн гэрээнд нийлүүлбэл зохих нийт 69 бүтээгдэхүүн, тусгай захиалгат бүтээгдэхүүн 5, өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх 3 зорилт дэвшүүлэн ажиллаж, гэрээгээр хүлээсэн үүргээ 91,5 хувь буюу “А” үнэлгээтэй биелүүлсэн.

Газрын төлбөрийн орлогын бүрдүүлэлтийг сайжруулахад анхаарч, холбогдох мэргэжлийн байгууллага, сум орон нутгийн удирдлагуудтай хамтарч ажилласны дүнд газрын төлбөрийн орлогоор 295000,0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, төлөвлөгөөг 101%-тай биелүүлсэн.

Аймгийн Засаг даргаас Тээвэр, авто замын газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Байгуулсан үр дүнгийн гэрээнд нийлүүлбэл зохих нийт 22 бүтээгдэхүүн, тусгай захиалгат бүтээгдэхүүн 3, өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх 3 зорилт дэвшүүлэн ажиллаж, гэрээгээр хүлээсэн үүргээ 84,0 хувь буюу “В” үнэлгээтэй биелүүлсэн.

Нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах зорилт тавьж ажилласнаар хот хоорондын 1, орон нутгийн 2, хотын дотор 2 чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээний шинэ чиглэл нээж, 27034 иргэнд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлсэн нь өнгөрсөн оноос зорчигч урсгалын хэмжээ 13,0 хувиар өссөн байна.

Аймгийн Засаг даргаас Статистикийн хэлтсийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт “91.8” хувь буюу “А” дүнтэй үнэлэгдлээ. Гол үр дүн нь 2010 оны хүн ам, орон сууцны тооллогыг аймгийн хэмжээнд амжилттай зохион байгуулж, хугацаанд нь Үндэсний Статистикийн хороонд хүргүүлсэн. Тооллогоор нийт 1021 хүн ажилласан ба 427 үндсэн тоологчоор, бусад нь сум багийн түр товчооны гишүүд байлаа. Хүн ам орон сууцны тооллогын ажлыг орон нутгийн төсвөөс 97,6 сая төгрөгөөр санхүүжүүлж, батлагдсан зориулалтын дагуу зарцуулсан. Тооллогын дүнгээр 16 сум, 74 багийн 15800 өрхийн 53330 хүн бүртгэгдлээ.

Аймгийн Засаг даргаас Татварын хэлтсийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт “93,9” оноо буюу “А” дүнтэй үнэлэгдлээ. Гол үр дүн нь орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 105,7 хувь, улсын төсвийн орлогын төлөвлөгөөг 103,0 хувьтай биелүүлсэн. Татварын хэлтсийн www.bulgan-mta.mn вэб сайтыг хийж, интернэтэд байрлуулж, үйл ажиллагаагаа ил тод нээлттэй сурталчилж байна

Аймгийн Засаг даргаас Онцгой байдлын газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Онцгой байдлын газрын дарга нь гэрээгээр хүлээсэн үүргээ 98,5 хувь буюу “А” үнэлгээтэй биелүүлсэн бөгөөд ажлаараа Онцгой байдлын ерөнхий газарт тэргүүн байр эзэлсэн амжилттай ажиллалаа.

Ой хээрийн түймэрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэн БОАЖГ, МХГ, ЦХ, Хилийн цэргийн 0186-р ангитай хамтран ажилласны дүнд ой хээрийн түймэрийн тоо 8 буюу 40 хувь хохирол 322.1 сая төгрөгөөр унтраахад гарсан зардал 11784110 төгрөг буюу 17 дахин буурсан байна.

Аймгийн Засаг даргаас Мэргэжлийн хяналтын газрын даргатай байгуулсан үр дүнгүйн гэрээний хэрэгжилт:

Мэргэжлийн хяналтын газрын дарга нь нийт 23 ангийн 440 бүтээгэдэхүүн нийлүүлж ажилласнаар 97,7 хувийн биелэлтэйгээр үнэлэгдлээ.

Давхардсан дүнгээр байгууллага аж ахуйн 1465 нэгж, 180 салбар, 763 цэг байгууламжид 16645 хүн хамруулсан шалгалт хийж, 3849 зөрчил илрүүлэн 3115 буюу 80,9 хувийг нь арилгуулсан байна. Зөрчил гаргасан 28 ААН байгууллага, 80 иргэн, 84 албан тушаалтанд 4899,0 мян төгрөгийн торгууль, шийтгэвэр ногдуулж 89.5 хувийг нь барагдуулжээ.

Аймгийн Засаг даргаас Цагдаагийн хэлтсийн даргатай байгуулсан үр дүнгүйн гэрээний хэрэгжилт:

Аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтэс 2010 онд дэвшүүлсэн зорилтоо бүрэн хангаж ажилласны дотор байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, иргэд олон нийттэй ойрхон ажиллах тал дээр идэвхи санаачлагатай ажиллаж, Алба хаагчдийн сахилга ёс зүйг сайжруулах талаар амжилт гаргаж гэрээний биелэлтийг 90,9 хувь буюу А үнэлгээтэй дүгнэгдлээ.

Аймгийн Засаг даргаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны даргатай байгуулсан үр дүнгүйн гэрээний хэрэгжилт:

Шийдвэр гүйцэтгэлийн алба гүйцэтгэх хуудасны бодит биелэлтийг 70,2 хувь, мөнгөн дүнгүйн биелэлтийг 57 хувьд хүргэж, шийдвэр гүйцэтгэлийн хувийг улсын дунджаас бууруулаагүйн дээр цагдан хорих байрны оргодол болон өвчлөлт гаргалгүй ажиллаж гэрээний үүргээ 91,1 хувьтай А үнэлгээтэй биелүүллээ.

Аймгийн Засаг даргаас Шүүхийн шинжилгээний албаны даргатай байгуулсан үр дүнгүйн гэрээний хэрэгжилт:

Шүүхийн шинжилгээний албаны даргатай байгуулсан үр дүнгүйн гэрээнд бүгд 48 заалт тусгагдсанаас 98.7 хувийн биелэлттэй хэрэгжүүлж ажилласан. Байгууллагын үйл ажиллагаа, нээлттэй ил тод байдлыг илтгэсэн самбарыг байгууллагын үүдэнд байрлуулж тухай бүр нь мэдээллийг шинэчилж, байгууллагын үйл ажиллагааны талаар болон Шүүхийн шинжилгээний тухай хуулийг олон нийтэд сурталчилж, үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг хангасан.

Мөн өөрсдийн үйл ажиллагааны талаархи мэдээллийг интернетэд цахим хуудас нээж байршуулсан ба иргэдээс өргөдөл, санал хүсэлтийг цахим хэлбэрээр авч хэвшсэн бөгөөд Үр дүнгүйн гэрээг 96,8 буюу “Хангалттай сайн” гэж дүгнүүллээ

Аймгийн Засаг даргаас Улсын бүртгэлийн хэлтсийн даргатай байгуулсан үр дүнгүйн гэрээний хэрэгжилт:

Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаагаар нийт 35, тусгай захиалгат 4 бүтээгдэхүүнийг авахаар Үр дүнгүйн гэрээ байгуулж ажилласан. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивыг цахимжуулж 6308 хувийн хэргийг мэдээлэлд бүрэн оруулж, иргэний шинэчилсэн бүртгэлийн бэлтгэл ажлыг сайн хангаж, хамрагдвал зохих

41845 иргэнээс 39112 иргэнийг хамруулж 93,5 хувьтай хэрэгжүүлэв. Үйл ажиллагааны орлогоор улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 30,0 сая төгрөгөөр давуулан биелүүлж, төсвийн өр авлагагүй ажиллаж Үр дүнгийн гэрээний биелэлтийг 94,5 буюу “Хангалттай сайн” гэж дүгнэгдлээ.

Аймгийн Засаг даргаас аймгийн Засаг даргын Тамгын газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Тусгай захиалгат бүтээгдэхүүнээс бусад нийлүүлбэл зохих бүтээгдэхүүн 59, Нийлүүлбэл зохих тусгай захиалгат бүтээгдэхүүн 54, Өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх талаар дэвшүүлсэн зорилт 10-ийг дэвшүүлж ажилласнаар гэрээний хэрэгжилт 90,5 хувиар биелэлээ.

Төрийн албаны стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахисан болно. Аймгийн Засаг даргын тамгын газар нь өөрийн дүрэмд тусгагдсан чиг үүргийг /ажил үйлчилгээг/ бүтээгдэхүүн нийлүүлэх хэлбэрээр үйл ажиллагааны үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлж гэрээг биелүүлэхэд шаардагдах санхүүжилтийг бүрэн авч ажиллав. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулав. Гэрээнээс гадуур бүтээгдэхүүнээ худалдаагүй. Үндсэн бус үйл ажиллагаанаас 0.34 сая төгрөгийн орлого олов. Цалингийн сангийн хэмнэлтээс үйл ажиллагаа, мэргэжлийн түвшингийн үнэлгээ, үр дүнгийн гэрээ болон өгсөн үүрэг даалгаварын биелэлт дүнд үндэслэн ажилтнуудыг урамшуулахад 4,0 сая төгрөг зарцуулав. Гэрээгээр хүлээсэн үүрэг, батлагдсан төсөвт багтааж үйл ажиллагаагаа явуулав.

2010 онд 124,8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүрдүүлэн бүртгэлд авч, жилийн эцсийн тоо бүртгэлийн дүнд үндэслэн 3,8 сая төгрөгийн эд хөрөнгийг актлаж, 71,4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг аймгийн ИТХ-ын шийдвэрээр балансаас балансад шилжүүлэв.

53,2 төгрөгийн үнэ бүхий 3 орон сууцыг төрийн албан хаагчдад бүртгэлийн үнээр нь хувьчлав. Аймгийн Засаг даргын тамгын газрын дүрэм, байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад төсвийг зориулж ашиглав.

Аймгийн Засаг даргаас Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээг дүгнээгүй бөгөөд уг хэлтсийн дарга хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа болно. Аймгийн Засаг даргаас Нийгмийн даатгалын хэлтсийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ нь өмнөх даргатай байгуулсан бөгөөд шинэ дарга нь ажилд томилогдоод 3 сар болж байгаа тул гэрээг дүгнэсэнгүй.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР